




БАЯНХОНГОР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

БАЯНХОНГОР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН

2025 I



<https://bayankhongor.nso.mn/>



Баянхонгор аймаг
2025 он

**БАЯНХОНГОР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС**

НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДЛЫН САРЫН ТАНИЛЦУУЛГА

2025
1 сар

Баянхонгор хот

2025

I Саруудыг ром тоогоор тэмдэглэв.

- Сар: I, II, III, IV, V ... г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-XI ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав).

II Дараах тэмдэглэгээг ашиглав.

- ... мэдээлэл байхгүй
- 0.0 маш бага тоо
- - гүйцэтгэл байхгүй
- * урьдчилсан гүйцэтгэл

III Хэмжих нэгжийн тэмдэглэгээ

- мянга =1000
- сая =10
- тэрбум =10
- их наяд =10¹²
- % хувь
- мм миллиметр
- см сантиметр
- дм дециметр
- м метр
- км километр
- м² метр квадрат
- дм² дециметр квадрат
- км² километр квадрат
- м³ метр куб
- га гектар
- мл миллилитр
- л литр
- г грамм
- кг килограмм
- Вт ватт
- кВт цкиловатт цаг
- калкалори ккалкилокалори
- Гкал гигакалори(=10⁹ калори)
- мкг/м³ микрограмм метр куб
-  Үүнээс гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно

ГАРЧИГ

I. Хүн ам.....	5
II. Эрүүл мэнд.....	6
III. Хөдөлмөр эрхлэлт.....	9
IV. Халамж, нийгмийн даатгал.....	11
V. Гэмт хэрэг.....	16
VI. Мөнгө, зээл.....	18
VII. Төсвийн орлого.....	20
VIII. Хэрэглээний үнэ.....	21
IX. Хөдөө аж ахуй.....	24
X. Аж үйлдвэр.....	26
XI. Барилга.....	28
Хавсралт хүснэгтийн жагсаалт.....	44
.....	
.....	

ХЭВЛЭЛИЙН ЭХ БЭЛТГЭЖ, ТАНИЛЦУУЛСАН
ХЭЛТСИЙН ДАРГА Г.ГАНЧИМЭГ




ХҮН АМ


2025 оны 1 дүгээр сард

1 дүгээр сард 101 эх амаржиж, 1 000 ногдох төрөлт 1.1 болж өмнөх оноос өөрчлөлт ороогүй, 1 000 хүн ноогдох нас баралт 0.4 болж өмнөх оны мөн үеэс 0.1 нэгжээр өссөн байна.

ЗУРАГ 1. ТӨРӨЛТ, 1 000 НОГДОХ ТӨРӨЛТ, жил бүрийн 1 дүгээр сард



ЗУРАГ 2. НАС БАРАЛТ, 1 000 НОГДОХ НАС БАРАЛТ, жил бүрийн 1 дүгээр сард



2025 оны 1 дүгээр сард нас баралт 38 болж, өмнөх оноос 8 (26.7%)-аар нэмэгдэж. 1 000 хүнд ногдох төрөлт 1.1, нас баралт 0.4, ердийн цэвэр өсөлт 0.7 байна.

Ойлголт, тодорхойлолт:

Хүн амын ердийн цэвэр өсөлт нь Төрөлт, нас баралтын зөрүүгээр

Эх үүсвэр:

Аймгийн Эрүүл мэндийн газар

Мэдээлэл авах холбоос:

<https://bayankhongor.nso.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2025 оны 3 дугаар сарын 15



ЭРҮҮЛ МЭНД

2025 оны 1 дүгээр сард

НИЙТ ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГЧИД



2024 | 76


2025 | 78

2.6% ↑



ЭМНЭЛЭГТ ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЭГЧИД

мянган хүнээр



2024 | 2.4

2025 | 2.6

8.3% ↑



1-5 хүртэлх насны хүүхдийн
эндэгдэл

2024 | 1

2025 | 0

Осол гэмтэл

2024 | 66

2025 | 85

28.8% ↑



Тайлант сард 28.9 мянган хүн үзлэгт хамрагджээ.

Эрүүл мэндийн газрын мэдээгээр 2025 оны 1 дүгээр сарын байдлаар амбулаторийн үзлэгт 28.9 мянган хүн хамрагдаж, 2.3 мянган үйлчлүүлэгч эмчлэгдэн 17279 ор хоног ашиглаж, дундаж ор хоног 7.2 байна. Нийт үзлэгийн 5.3 (18.4%) мянган урьдчилсан сэргийлэх үзлэгт хамрагдсан. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад амбулаторийн үзлэг 4.6 (19.1%) мянган хүнээр, хэвтэн эмчлүүлсэн хүн 0.2 (6.5%) мянган хүнээр тус тус нэмэгдсэн байна.

Урьдчилан сэргийлэх тарилгын хамрагдалт 1 дүгээр сарын байдлаар 98.9% хувьтай.


ХҮСНЭГТ 1. ЭРҮҮЛ МЭНДИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн 1 дүгээр сард

Үндсэн үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 I	2024 I	2025 I	2024 I 2025 I
		тоо			хувь
Амаржсан эх	тоо	135	100	101	1.0
Амьд төрсөн хүүхэд	тоо	138	100	101	1.0
0-1 насны хүүхдийн эндэгдэл	тоо	2	1	0	0.0
1-5 насны хүүхдийн эндэгдэл	тоо	0	0	0	0
Нас баралт	тоо	37	30	38	26.7
Халдварт өвчин	тоо	70	76	78	2.6
Хорт хавдрын өвчлөл	тоо	5	5	10	2.0 ¹
Осол гэмтэл	тоо	76	66	85	28.8
Бүртгэгдсэн өвчлөл	мян.хүн	8.2	8.1	8.5	4.9
Эмчийн үзлэг	мян.хүн	26.3	24.3	28.9	18.9
Эмчлүүлсэн хүний тоо	мян.хүн	2.1	2.3	2.3	0
Ор хоног	мян.хүн	15.0	16.9	17.2	1.8
Түргэн тусламжийн дуудлага	тоо	1 577	1 328	1 226	-7.7
Үүнээс: алсын дуудлага	тоо	310	298	274	-8.1


¹Дахин их

Тайлант сард аймгийн хэмжээнд 78 халдварт өвчин бүртгэгдэж 10 000 хүн амд 8.8 болж өмнөх оны мөн үетэй 0.2 нэмэгдсэн. БЗДХ-ын тохиолдлын тоо урьд оны мөн үеэс 14 (28.6%) өсч, нийт халдварт өвчний 80.8 хувийг эзэлж байна.

ЗУРАГ 3. ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГЧИД, бүтцээр, 1 дүгээр сард



ЗУРАГ 4. ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГЧДИЙН ӨСӨЛТ, БУУРАЛТ, продицимилээр, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар



Артерийн гипертензийн эрт илрүүлэгийн үзлэгт 2 369 хүн хамрагдсанаас эрэгтэйчүүд 867(36.6%) эзэлж байна.

Ойлголт, тодорхойлолт

Төрөлт: Хүн төрөлхтний дунд явагдаж буй нөхөн үржихүйн бодит үзэгдэл бөгөөд эмэгтэйчүүдийн амьд төрүүлсэн хүүхдийн тоогоор хэмжигдэнэ.

Төрөлтийн ерөнхий коэффициент: Тухайн жилийн 1000 хүн тутамд ногдох амьд төрсөн хүүхдийн тоог илэрхийлнэ.

Нас баралт: Хүн төрөлхтний дунд гарч буй нөхөн үжихүйн үзэгдлийн нэг. Хүн амын амьжиргааны түвшин, амьдралын хэв маяг, эрүүл ахуйн нөхцөл, өвчлөл нь нас баралтын түвшинд нөлөө үзүүлдэг учир энэ үзүүлэлтийг нас баралтын шалтгаанаар нь тодорхойлж болно.

Нас баралтын ерөнхий коэффициент: Тухайн жилийн 1000 хүн тутамд ногдох нас баралтын тоог илэрхийлнэ.

Хүн амын ердийн цэвэр өсөлт, бууралт: Тухайн жилийн хүн амын төрөлт, нас баралтын тооны зөрүүгээр илэрхийлэгдэнэ.

Эх үүсвэр:

Аймгийн Эрүүл мэндийн газар

Мэдээлэл авах холбоос:

<https://bayankhongor.nso.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:


2025 оны 3 дугаар сарын 15




ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

2025 оны 1 дүгээр сарын байдлаар

БҮРТГЭЛТЭЙ АЖИЛ ХАЙГЧ ИРГЭД



БҮРТГЭЛТЭЙ АЖИЛ ХАЙГЧ ИРГЭД, боловсролын түвшингээр





Тайлант сард 90 иргэн ажилд зуучлагдан орсон байна.

Аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газарт тайлант сард 86 иргэн бүртгүүлж бүртгэлтэй ажил хайгч иргэдийн тоо 725 болсны 370 (51.0%) эмэгтэйчүүд байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 569 (78.5%) 15-44 насныхан эзэлж байгаа юм.

2025 оны 1 дүгээр сарын байдлаар 302 ажлын байрны захиалга ирж, байнгын шинэ ажлын байраар 46 иргэн хангагджээ.

ХҮСНЭГТ 2. АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН АНГИЛЛААР

Салбар	Ажлын байрны захиалга
Нийт	302
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	12
Боловсрол	5
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	5
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	1
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	3
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	2
Барилга	2
Мэдээлэл, холбоо	2
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	60
Боловсруулах үйлдвэр	8
Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	190
Бөөний болон жижиглэн худалдаа машин мотоциклийн засвар үйлчилгээ	11
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	1

Тайлант сард бүртгэлтэй ажилгүй иргэдээс 90 иргэн ажилд зуучлагдан орсны 11 (12.2%) бакалавр, 49 (54.4%) бүрэн дунд боловсролтой иргэд байна.

Ойлголт, тодорхойлолт

Ажил хайгч иргэн: Ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж байгаа иргэнийг ойлгоно.

Хөдөлмөрийн насны хүн ам: 15, түүнээс дээш насны хүн амыг хэлнэ. Хөдөлмөрийн насны хүн амыг ажиллах хүч болон ажиллах хүчнээс гадуурх хүн ам гэж ангилна (заалт 15, 65, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-I).

Хөдөлмөр: Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт бүртгүүлсэн хүмүүс орсон болно.

Эх үүсвэр:

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар

Мэдээлэл авах холбоос:

<https://bayankhongor.nso.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2025 оны 3 дугаар сарын 15



НИЙГМИЙН ХАЛАМЖ

2025 оны 1 дүгээр сарын байдлаар

НИЙГЭМ



НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ 5 265.2 сая төгрөг улсын төсөв



Цалинтай ээж
Хөтөлбөр 168.3



Өрх толгойлсон эцэг,
эхийн хөтөлбөр 3.7



Ихэр хүүхэд төрүүлж эсэн
мэнд өсгөж байгаа өрх,
иргэнд олгох тэтгэмж 2.0



Хүнс тэжээлийн
дэмжлэг 59.6

Жирэмсэн эхийн
тэтгэмж 22.1



Ахмад настны нийгмийн
хамгааллын тусламж,
хөнгөлөлт 12.7




Хөгжлийн бэршээлтэй иргэний
тусламж, хөнгөлөлт 9.4



НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ 4.8 сая төгрөг орон нутаг




Амьжиргааг дэмжих
нөхцөлт мөнгөн тэтгэмж 4.8




Нийгмийн халамжийн сангаас 1 дүгээр сард хүүхдийн мөнгөн тэтгэмжийн зардалд 3 427.4 сая төгрөгийг олгожээ.

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээгээр 2025 оны 1 сарын байдлаар 47.4 мянган иргэнд 5.3 тэрбум төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, урамшуулалд олгожээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хамрагдсан иргэд 13.5 (22.2%) мянган хүнээр, олгосон тэтгэвэр, тэтгэмж 1.2 (18.6%) тэрбум төгрөгөөр буурсан тус тус байна.

ЗУРАГ 5. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮНИЙ, ТОО, мянган хүн, жил бүрийн 1 сард



ЗУРАГ 6. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРЛАГА, тэрбум төгрөг, жил бүрийн 1 сард



Орон нутгийн төсвөөс амьжиргаа дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж 2 иргэнд 4.8 сая төгрөгийг олгосон байна.

Ойлголт, тодорхойлолт

Нийгмийн халамж Эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан хүнийг

Бүтэн өнчин хүүхэд эцэг, эх нь тогтоогдоогүй, эсхүл эцэг, эх нь хоёул нас барсан, сураггүй алга болсон, эрх зүйн чадамжгүй, эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, түүнчлэн эцэг тодорхойгүйн улмаас эхтэйгээ амьдарч байгаад эх нь нас барсан, гэр бүл салсны улмаас асрамждаа авсан эх /эцэг/ нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдийг

Өрх толгойлсон эх /эцэг/ нөхөр, эхнэрийн аль нэг нь нас барсан, эсхүл сураггүй алга болсон нь шүүхээр тогтоогдсон, гэрлэлтээ цуцлуулсан, эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, гэрлэж байгаагүй боловч төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэдтэй ганц бие эх /эцэг


Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотойгоор өрх, иргэнд дэмжлэг туслалцаа, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг.

Эх үүсвэр:

аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар

Мэдээлэл авах холбоос: <https://bayankhongor.nso.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2025 оны 3 дугаар сарын 15




НИЙГМИЙН ДААТГАЛ

2025 оны 1 дүгээр сарын байдлаар

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН, тэрбум төгрөг

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН, тэрбум төгрөг




* ҮОМШӨ - Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ДААТГАЛЫН САНГААС ТЭТГЭВЭР АВАГЧИД

Тэтгэврийн даатгалын сан

Тэтгэмжийн даатгалын сан



Нийт 174

ҮОМШӨ-ний сангаас 23

Ажилгүйдлийн даатгалын сангаас 151



Тайлант оны 1 дүгээр сард 11.1 мянган өндөр настанд 8.6 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгожээ.

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээгээр нийгмийн даатгалын сангаас 13.6 мянган иргэнд 10.9 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон. Өмнөх оны мөн үеэс тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо 250 (24%), 2.5 (30.6%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

ХҮСНЭГТ 3. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, төрлөөр, жил бүрийн 1 дүгээр сард

Үзүүлэлт	2023 I	2024 I	2025 I	<u>2025 I</u> 2024 I
	сая төгрөг			хувь
Нийт зарлага	6 812.0	8 355.1	10 911.4	30.6
Тэтгэврийн даатгалын сан	6 526.4	7 952.9	10 102.9	27.0
Тэтгэмжийн даатгалын сан	161.8	260.2	514.3	97.7
ҮОМШӨ-ний даатгалын сан	31.4	70.8	27.8	-60.7
Ажилгүйдлийн даатгалын сан	92.4	71.2	266.4	74.0 ¹

¹Дахин их

2025 оны 1 дүгээр сарын байдлаар ажилгүйдлийн тэтгэмжийн зардал 266.4 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 195.2 (274.0%) сая төгрөгөөр өссөн байна.

ХҮСНЭГТ 4. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, АВАГЧДЫН ТОО төрлөөр, жил бүрийн 1 дүгээр сард

Үзүүлэлт	2023 I	2024 I	2025 I	<u>2025 I</u> 2024 I
	тоо			зөрүү
Нийт	13 118	13 370	13 620	250
Өндөр насны тэтгэвэр	10 522	10 789	11 082	293
Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр	1 673	1 723	1 542	- 181
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	500	491	467	- 24
Цэргийн тэтгэвэр	146	157	165	8
ХЧТА-ны тэтгэмж	64	3	28	25
Жирэмсний болон амаржсаны тэтгэмж	112	67	125	58
Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж/оршуулгын/	32	29	37	8
Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр	18	18	15	- 3
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	9	8	8	-
Ажилгүйдлийн тэтгэмж	42	85	151	66

Ойлголт, тодорхойлолт

Нийгмийн даатгал: Иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын сан: Ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад

эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Даатгуулагч: Хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Тэтгэвэр: Даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

Тэтгэмж: Хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний, амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болох тохиолдолд даатгуулагч өөрт нь, даатгуулагч нас барах тохиолдолд гэр бүлд нь хууль заасан болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас тодорхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор байна.

Эх үүсвэр:

Аймгийн Нийгмийн даатгалын газар

Мэдээлэл авах холбоос:

<https://bayankhongor.nso.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2025 оны 3 дугаар сарын 15



ГЭМТ ХЭРЭГ

2025 оны 1 дүгээр сарын байдлаар

Урьдчилсан



Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг

2024 I
76

2025 I
131
72.4% ↑



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад

Гэмт хэргийн улмаас



Хохирсон хүн

120 40.0% ↑



Гэмтсэн хүн

33 6.1% ↑



Нас барсан хүн

8 62.5% ↑

2024 I

Нийт бүртгэгдсэн зөрчил **2 607**

2025 I

3 033
16.3% ↑



Торгууль шийтгэл
оногдуулсан

2 884



Баривчлагдсан

23



Хэрэгсэхгүй
болгосон

1



Тээврийн хэрэгсэл
жолоодох эрх хасах

61



Гэмт хэргийн улмаас 310.0 сая төгрөгийн хохирол учирснаас 48.9 сая төгрөгийг нөхөн төлүүлжээ.


Аймгийн Цагдаагийн газрын мэдээгээр 1 дүгээр сард бүртгэгдсэн 131 гэмт хэргийн 31 (23.7%) хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 45 (34.4%) залилах, 15 (11.5%) хулгайлах, 12 (9.2%) малын хулгай, 10 (7.6%) хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргүүд энэ нь нийт гэмт хэргийн 86.4 хувийг эзэлж байна.

Иргэн хуулийн этгээдээс гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 592 гомдол мэдээлэл хүлээн авч шалгасан энэ нь өмнөх оны мөн үеэс 216 (57.4%) өссөн. Гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл өмнөх оноос 69 (51.1%), зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 147 (61%) тус тус өссөн байна.

ЗУРАГ 6. ГЭМТ ХЭРГИЙН ШИНЖТЭЙ ГОМДОЛ МЭДЭЭЛЭЛ ШИЙДВЭРЛЭЛТ хувиар, 1 дүгээр сард




ЗУРАГ 7. ЗӨРЧЛИЙН ШИНЖТЭЙ ГОМДОЛ МЭДЭЭЛЭЛ ШИЙДВЭРЛЭЛТ хувиар, 1 дүгээр сард



Бүртгэгдсэн гэмт хэргийн 6 (4.6%) гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 16 буюу (12.2%) согтуугаар, 13 (9.9%) эмэгтэй хүн оролцож, 32 (24.4%) цахим орчинд, 1 (0.8%) бүлэглэн үйлдсэн байна.

ЗУРАГ 8. ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГДСЭН БАЙДАЛ тоогоор жил бүрийн 1 дүгээр сард



Аймгийн хэмжээнд 1 дүгээр сарын байдлаар 3033 зөрчил бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 426 (16.3%) өссөн үзүүлэлтэй байна. Энэ хугацаанд 7 иргэн эрүүлжүүлж, 38 хүнийг саатуулагдсан нь өмнөх оны мөн үеэс эрүүлжүүлсэн 5 (41.7%), саатуулагдсан хүн 9 (19.1%) тус тус буурсан.

Ойлголт, тодорхойлолт

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

Хохирогч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Эх үүсвэр: Аймгийн Цагдаагийн газар



МӨНГӨ, ЗЭЭЛ

2025 оны 1 дүгээр сарын байдлаар

МОНГОЛЫН
БАНК



**Нийт
зээлдэгчийн
тоо**



2024 I

59715

2025 I

64062



**Зээл
2025 I**

Нийт олгосон зээлийн өрийн үлдэгдэл

501.3
тэрбум төгрөг




9.3
тэрбум төгрөг

Анхаарал хандуулах
зээлийн өрийн үлдэгдэл



7.4
тэрбум төгрөг

Чанаргүй
зээл



Нийт
хадгаламжийн
үлдэгдэл



тэрбум төгрөг

201.2

Хугацаатай
хадгаламж



тэрбум төгрөг

34.8

Хугацаагүй
хадгаламж



тэрбум төгрөг

166.4



Нийт банкны салбар, нэгжийн
ажилтнуудын тоо
232

АТМ-ны тоо **43**



Чанаргүй зээлийн үлдэгдэл 1.4 тэрбум төгрөгөөр өсчээ.

Монгол банкны аймаг дахь салбараас ирүүлсэн мэдээгээр 2025 оны 1 дүгээр сард арилжааны банкнуудын нийт хадгаламжийн үлдэгдэл 201.2 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 47.2 (30.7%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

ХҮСНЭГТ 6. ХАРИЛЦАХЫН ҮЛДЭГДЭЛ, ХАДГАЛАМЖ, жил бүрийн 1 дүгээр сарын эцэст

Үзүүлэлт	2023 I	2024 I	2025 I	2025 I 2024 I
	сая төгрөг			хувь
Нийт	131 316.1	153 899.3	201 197.4	30.7
Хугацаагүй хадгаламж	18 053.1	26 830.9	34 805.7	29.7
Хугацаатай хадгаламж	113 263.0	127 068.4	166 391.7	30.9


Нийт зээлийн үлдэгдлийн 484.6 (96.7%) тэрбум төгрөгийн хэвийн зээл, 9.3 (1.8%) тэрбум төгрөгийн анхаарал хандуулах зээл, 7.4 (1.5%) тэрбум төгрөгийн чанаргүй зээл байна. Чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 1.4 (24.2%) тэрбум төгрөгөөр өссөн.

ХҮСНЭГТ 7. НИЙТ ЗЭЭЛ, ангилал, жил бүрийн 1 дүгээр сарын эцэст

Үзүүлэлт	2023 I	2024 I	2025 I	2025 I 2024 I
	сая төгрөг			хувь
Нийт	272 646.3	343 549.4	501 295.5	51.7
Хэвийн зээл /хугацаандаа төлөгдөж байгаа	262 407.1	332 471.4	484 585.6	45.8
Анхаарал хандуулах зээл	5 764.9	5 126.7	9 317.4	81.7
Чанаргүй зээл	4 474.3	5 951.3	7 392.5	24.2

Аймгийн хэмжээнд банкны 55 салбар нэгжид 232 ажилтан ажиллаж, зээлдэгчид 64.1 мянга, харилцах данс эзэмшигчид 143.5 мянга, хадгаламж эзэмшигчид 66.3 мянган хүн байна.

ЗУРАГ 9. ХАДГАЛАМЖ ЭЗЭМШИГЧ, ЗЭЭЛДЭГЧИЙН ТОО, хүн, жил бүрийн 1 дүгээр сарын эцэст



Ойлголт, тодорхойлолт

Хэвийн зээл: Төлөвлөгдсөн хугацаанд байгаа зээл, түүний хүүг ойлгоно.

Хугацаа хэтэрсэн зээл: Зээл, хүүгийн хугацаа 90 хүртэл хоног хэтэрсэн зээлийг хамруулна.

Чанаргүй зээл: Хэвийн бус, эргэлзээтэй, муу зээл буюу зээл, хүүгийн хугацаа 91-ээс дээш хоног хэтэрсэн зээлийг хамруулна.

Эх үүсвэр: Баянхонгор аймаг дахь Монгол банкны салбар

Мэдээлэл авах холбоос: <https://bayankhongor.nso.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2025 оны 3 дугаар сарын 15



Аймгийн төсвийн орлогын төлөвлөгөө 28.3 хувиар давж биелжээ.

Аймгийн Татварын газрын мэдээгээр 1 дүгээр сард татварын орлогод 2 520.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлж орлогын төлөвлөгөө 533.9 (26.9%) сая төгрөгөөр давж биелсэн байна. Үүнээс аймгийн төвлөрсөн төсөвт 205.5 сая, сумдын төсөвт 1 866.7 сая, улсын төсөвт 448.3 сая төгрөгийг тус тус төвлөрүүлжээ.

ХҮСНЭГТ 8. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, жил бүрийн эхний 1 дүгээр сард, сая төгрөг


Үзүүлэлт	2023 I	2024 I	2025 I		Биелэлт хувь	2025 I 2024 I
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Нийт	933.9	2 192.8	2 172.4	2 787.0	28.3	27.1
Татварын орлого	871.3	2 015.3	1 986.8	2 520.6	26.9	25.1
Татварын бус орлого	62.6	177.5	185.6	266.4	43.5	50.1

Татварын бус орлого 80.1 (43.5%) сая төгрөгөөр давж биелсэн байна. Хүү торгуулийн орлого нийт орлогын 96 хувийг эзэлж байна.

Татварын орлого дүнгээр 26.9 хувиар давж биелсэн боловч Ус рашаан ашигласны төлбөр 5 730.5 (26%), сая, газрын төлбөр 2 963.4 (47.8%) сая төгрөгөөр тасарсан байна.

ЗУРАГ 10. ТАТВАРЫН БУС ОРЛОГО, төрөлд эзлэх хувиар 1 дүгээр сард

Газрын дуудлага худалдааны орлого 1%



Төсвийн нийт зарлага 1 дүгээр сарын эцэст 16 440.28 сая төгрөг үүний 15 644.8 (95.2%) сая төгрөг нь урсгал зардал, 795.3 (4.8%) сая төгрөгийг хөрөнгийн зардалд тус тус зарцуулсан байна.

Ойлголт, тодорхойлолт

Орон нутгийн төсөв: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга бүрдүүлж, зарцуулах төсөв юм.

Орон нутгийн төсвийн орлого: Татварын орлого, татварын бус орлого, хөрөнгийн орлогоос бүрдэнэ.

Татварын орлого: Орлогын албан татвар, өмчийн албан татвар, бусад татвар, хураамжаас бүрдэнэ.

Татварын бус орлого: Түрээсийн орлого, хүүгийн орлого, торгуулийн орлого, нэр зааж ангилагдаагүй орлого, төсөвт байгууллагын өөрийн орлогоос бүрдэнэ.

Эх үүсвэр:

аймгийн Татварын газар, CTCX

Мэдээлэл авах холбоос:

<https://bayankhongor.nso.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:


2025 оны 3 дугаар сарын 15



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС

1 дүгээр сарын байдлаар

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС





Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеэс 10.2 хувиар өслөө.

Аймгийн хэмжээнд 2025 оны 1 дүгээр сард хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеэс 10.2 хувь, өмнөх сараас 1.2 хувиар өссөн байна. Энэ нь зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 28.5 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ 31.8 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 33.0 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлгийн үнэ 8.3 хувь, хүнсний бараа, ундаа усны бүлгийн үнэ 8.3 хувь, даатгал, санхүүгийн үйлчилгээ 95.2 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.

ХҮСНЭГТ 9. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, хувиар 2025 оны 1 дүгээр сард

Бараа үйлчилгээний бүлэг	2025 I 2024 I	2025 I 2024 XII
	хувь	
Ерөнхий индекс	10.2	1.2
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	8.3	1.3
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	4.8	4.1
Хувцас, бөс бараа, гутал	3.6	0.4
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад	31.8	0.2
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	1.8	0.9
Эм тариа эмнэлгийн үйлчилгээ	2.8	0.0
Тээвэр	-1.8	0.7
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	8.3	0.1
Амралт чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ	5.3	0.8
Боловсролын үйлчилгээ	17.4	0.0
Зочид буудал нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	28.5	0.0
Даатгал, санхүүгийн үйлчилгээ	95.2	95.2
Бусад бараа үйлчилгээ	33.0	3.8

ЗУРАГ 11. МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН, ТАЛХ, ГУРИЛ, БУДААНЫ ҮНИЙН ИНДЕКС (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар), сараар, хувиар



Аймгийн зарим гол нэр төрлийн бараа бүтээгдэхүүний дундаж үнийг өмнөх сартай харьцуулахад хонины мах (1кг) 11.2 хувиар, үхрийн цул мах (1кг) 5.3 хувиар, ямааны мах (1кг) 8.4 хувиар тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 10. ХҮНСНИЙ ГОЛ НЭР ТӨРЛИЙН БАРАА БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ДУНДАЖ ҮНЭ, төгрөг, сүүлийн 4 сараар

Нэр төрөл	Хэмжих нэгж	2024			2025	2025 I 2024 XII
		X	XI	XII	I	хувь
1-р зэргийн гурил	кг	2800	2800	2800	2775	-0.9
Хонины мах	кг	9375	9250	10900	12125	11.2
Үхрийн цул мах	кг	14250	14575	15200	16000	5.3
Ямааны мах	кг	8625	7875	8300	9000	8.4
Элсэн чихэр	кг	4850	4800	4780	4563	-4.5
Цагаан будаа	кг	3950	3900	3900	3825	-1.9
Шингэн сүү	л	6750	7375	9000	8875	-1.4

Ойлголт, тодорхойлолт

Хэрэглээний сагс: Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно.

Хэрэглээний үнийн индекс: Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Мэдээлэл авах холбоос:

<https://bayankhongor.nso.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2025 оны 3 дугаар сарын 15




ХӨДӨӨ АЖ АХУЙ

2025 оны 1 дүгээр сарын байдлаар

МЯНГАН ТОЛГОЙ

ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН МАЛ, жил бүрийн 1 дүгээр сард, дүнд эзлэх хувиар



ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, малын төрлөөр, 2025 оны 1 дүгээр сард





Аймгийн хэмжээнд 2025 оны 1 дүгээр сард 752 толгой мал хорогдлоо.


Том малын зүй бус хорогдол тайлант сард 752 болж, өмнөх оны мөн үеэс 10 760 (93.5%) толгойгоор буурсан. Нийт хорогдсон малын 37.1 хувийг ямаа эзэлж байна.

ХҮСНЭГТ 11. ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, төрлөөр, жил эхний 1 дүгээр сард

Малын төрөл	Хорогдсон мал			Оны эхний малд эзлэх хувь		
	2023 I	2024 I	2025 I	2023 I	2024 I	2025 I
	толгой тоо			хувь		
Бүгд	6 791	11 512	752	0.18	0.28	0.02
Адуу	268	517	98	0.17	0.29	0.06
Үхэр	1 478	2 533	192	0.66	1.06	0.09
Тэмээ	-	-	0	0.00	0	0
Хонь	2 348	2 329	183	0.21	0.19	0.02
Ямаа	2 697	6 133	279	0.12	0.26	0.01

Сумдаар авч үзвэл Эрдэнэцогт сум хамгийн өндөр буюу нийт том малын зүй бус хорогдлын 287 (37.8%) эзэлж байна.

ЗУРАГ 12. ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, сумаар, жил эхний 1 дүгээр сард



Ойлголт, тодорхойлолт:

Том малын зүй бус хорогдол: Гэнэтийн аюулаар буюу байгалийн аюулт үзэгдэл, өвчнөөр хорогдсон (халдвартай, халдваргүй), зэрлэг амьтанд идүүлсэн, бариулсан ба бусад шалтгаанаар хорогдсон төл малаас бусад малыг оруулна.

Оны эхний малд том малын зүй бус хорогдлын эзлэх хувь: Зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж тооцно.

Мэдээлэл авах холбоос:

<https://bayankhongor.nso.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:







2025 оны 3 дугаар сарын 15



АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ, ҮЙЛДВЭРЛЭЛ

2025 оны 1 дүгээр сарын байдлаар

Улаанбаатар хотын өмнөд хэсэгт байрладаг "Хөдөлмөр" аж үйлдвэрийн салбарын нийт, үйлдвэрлэл





Аж үйлдвэрийн салбарын борлуулалт өмнөх оны мөн үеэс 6.9 хувиар буурсан байна.

2025 оны 1 дүгээр сарын байдлаар аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл урьдчилсан гүйцэтгэлээр 8 357.4 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 621.2 (6.9%) сая төгрөгөөр буурсан байна.


ХҮСНЭГТ 12. НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, салбараар, жил бүрийн 1 сард

Салбар	2022 I	2023 I	2024 I	2025* I	2025* I 2024 I
	сая төгрөг				хувь
Нийт	8 974.9	4 711.3	8 978.6	8 357.4	-6.9
Уул уурхайн, олборлолт	7 845.3	3 055.4	6 653.7	5 269.0	-20.8
Боловсруулах үйлдвэрлэл	221.6	202.3	254.0	169.8	-33.1
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	695.3	1,256.7	1,619.0	2,437.4	50.5
Ус хангамж; сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	212.7	197.0	451.8	481.3	6.5

*-Урьдчилсан гүйцэтгэл

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 6.9 хувиар буурахад Уул уурхайн, олборлох салбарын нийт үйлдвэрлэл урьдчилсан гүйцэтгэлээр 5.2 тэрбум төгрөг болж 1.3 (20.8%) тэрбум төгрөгөөр буурсан нь гол нөлөө үзүүлж байна.

ЗУРАГ 13. УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ салбар, сая төгрөг, жил бүрийн 1 сард



Ойлголт, тодорхойлолт:

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл: Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн: Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Тайлбар: ААНБ-ын мэдээнд суурилсан гүйцэтгэл

Мэдээлэл авах холбоос:

<https://bayankhongor.nso.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2025 оны 3 дугаар сарын 15



Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэл 2024 онд 21.8 хувиар буурлаа.

Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэл 2024 онд 66.3 тэрбум төгрөг болж, 31.8 (32.4%) тэрбум төгрөгөөр буурахад орон сууцны барилга 20.2 (39.2%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлөв.

ХҮСНЭГТ 13. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, гүйцэтгэгчийн төрлөөр жил бүрийн эцэст

Төрөл	2021	2022	2023	2024*	<u>2024*</u> 2023
	сая төгрөг			хувь	
Дүн	31 558.8	37 190.1	98 150.0	66 309.6	-32.4
Дотоодын	31 558.8	35 539.5	84 775.6	66 309.6	-21.8
Хувийн	31 558.8	35 539.5	84 775.6	66 309.6	-21.8
Гадаад улсын	-	1 650.6	13 374.4	-	-

*-Урьдчилсан гүйцэтгэл

Орон сууцны бус барилгын ажил 2024 онд 2.4 (8.4%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Төрлөөр нь авч үзвэл худалдаа үйлчилгээний барилгынх 4.4 (70.7%) тэрбум, эмнэлгийн барилгынх 0.7 (93.5%) тэрбум, сургууль, соёлын барилгынх 2.4 (28.8%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан. Үйлдвэрлэлийн барилгынх 6.1 дахин өссөн үзүүлэлтэй байна

ХҮСНЭГТ 14. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, төрлөөр, сая төгрөг

Төрөл	2021	2022	2023	2024*	Өөрчлөлт	
					Дүн	Хувь
Нийт	31 558.8	37 190.1	98 150.0	66 309.7	-31 840.3	- 32.4
Орон сууцны барилга	18 116.3	20 696.4	51 542.2	31 316.3	-20 225.9	- 39.2
Орон сууцны бус барилга	13 204.5	13 324.3	29 074.0	26 629.4	-2 444.6	- 8.4
Үйлдвэрийн	-	-	950.0	5 787.0	4 837.0	6.1 ¹
Худалдаа, үйлчилгээний	1 540.0	406.8	6 305.0	1 850.0	-4 455.0	- 70.7
Эмнэлгийн	500.0	950.0	767.0	50.0	-717.0	- 93.5
Сургууль, соёлын	8 794.2	8 809.4	8 253.2	5 872.5	-2 380.7	- 28.8
Бусад	2 370.3	3 158.1	12 798.8	13 069.9	271.1	2.1
Инженерийн барилга, байгууламж	-	2 197.4	16 613.1	7 864.0	-8 749.1	- 52.7
Эрчим хүчний	-	1 650.6	13 374.3	-	-13 374.3	-
Авто зам	-	451.0	1 919.2	5 963.0	4 043.8	3.1 ¹
Гүүр, гүүрэн гарц	-	-	-	200.0	200.0	-
Далан, суваг, шугам, сүлжээ	-	-	1 100.0	1 400.0	300.0	27.3
Бусад (зам, талбайн бусад ажил)	-	95.8	219.5	301.0	81.5	37.1
Их засварын ажил	238.0	972.0	920.7	500.0	-420.7	- 45.7

¹-Дахин их

Бүлэг 11. Барилга

ЗУРАГ 14. БАРИЛГЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭСЭН БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, жил бүрийн эцэст, тэрбум төгрөг



Ойлголт, тодорхойлолт

Барилга угсралт, их засвар гэж барилга байшин барих болон инженерийн зориулалтаар зам, гүүр, далан зэрэг инженерийн бусад байгууламжийг барих хэлбэрээр үндсэн хөрөнгийг бий болгох, шинэчлэх, засварлах, өргөтгөхөд чиглэсэн үйл ажиллагааг ойлгоно.

Орон сууцны барилга нь хамгийн багадаа түүний тал хэсгийг нь орон сууцны зориулалтаар ашигладаг байгууламж юм.

